

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛАГИЙН ЯАМ,
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
НАРЫН ХАМТАРСАН ТУШААЛ

20.... оны сарын-ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын дарга нарын 2023 оны А/246, А/189 дүгээр хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааны журам”-ын 8.2 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй.

1/“8.2 дахь хэсэгт:

8.2.1.Тээвэрлэлтийн хамгаалалтад 24 цагаас илүү хугацаагаар үүрэг гүйцэтгэх тохиолдолд хамгаалалтад бүлэг (бүлгийн дарга, хамгаалалтын ажилтан, жолооч), 24 цагаас бага хугацаагаар үүрэг гүйцэтгэх тохиолдолд хамгаалалтын ажилтан, жолооч нарыг томилж, үүрэг гүйцэтгүүлнэ.”.

2.Мөн журмын 5.1 дэх хэсгийн “жолоодсон,” гэсний дараа “50 хүртэлх насны” гэж, 8.1 дэх хэсгийн “ашиглах,” гэсний дараа “өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндээ эрсдэлээс хамгаалах,” гэж, 8.10 дахь хэсгийн “дотоодын цэргийн алба хаагч” гэсний дараа “, бүлгийн дарга” гэж тус тус нэмсүгэй.

3.Мөн журмын 8.4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/“Наймдугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед тавих шаардлага

8.4.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээврийн замд харгалзан хүргэх хамгаалалтад хөтөч автомашин ажиллуулах бөгөөд хөтөч автомашины техникийн засвар үйлчилгээ болон шатах тослох материалын зардлыг Засгийн газрын тогтоолоор баталсан “Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэм”-д шийдвэрлэнэ.”.

4.Мөн журмын 4.2.4 дэх заалтын “гинжтэй байх” гэснийг “гинж, уулын тормос, зориулалтын контейнер тогтоогчтой байх” гэж, 8.2 дахь хэсгийн “алба хаагчийг” гэснийг “алба хаагчид (бүлэг)-ыг ” гэж, 8.3 дахь хэсгийн “алба хаагч нь” гэснийг “алба хаагчид (бүлэг) нь” гэж, 8.10 дахь хэсгийн “дотоодын цэргийн алба хаагч” гэснийг “дотоодын цэргийн алба хаагчид” гэж тус тус өөрчилсүгэй.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Салбарын хяналтын газрын дарга (Т.Өнөрнасан), Цагдаагийн ерөнхий газрын Дэд дарга (бригадын генерал О.Ганбат) нарт тус тус даалгасугай.

6.Тушаалыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС
БАЯЛАГИЙН САЙД
.....

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА, ДОТООДЫН ЦЭРГИЙН
КОМАНДЛАГЧ
.....

---oOo---